



ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ
СОНИРХОГЧ ЭТГЭЭДЭД

**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ТАМГЫН ГАЗАР**

Ж.Самбуугийн гудамж 18, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот 15170, Утас: 26 15 44,
Цахим шуудан: info@supremecourt.mn

2024. 08. 26 № 05/4388
танай _____-ны № _____-т

**Тендер шалгаруулалтыг
үргэлжлүүлэх тухай**

Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газраас зарласан УДШ/20240203009 дугаартай “Даатгалын үйлчилгээ” төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг сонирхогч этгээдээс гомдол гаргасантай холбогдуулан түр түдгэлзүүлсэн.

Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын 2024 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 01/1465 дугаар “Тендерийн баримт бичиг хянасан тухай” албан бичгээр тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 18.2-т заасан “2024 оны 1-р улирлын байдлаар төлбөрийн чадвар “Нэгдүгээр түвшин буюу даатгагчийн төлбөрийн чадвар сайн” түвшнийг хангасан байх (Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 599 дүгээр тогтоол “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд тавигдах журам”-ын 2.19) гэж заасан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасныг зөрчсөн, өрсөлдөөнийг хязгаарласан гэж үзэх үндэслэлгүй байна гэж хянажээ.

Иймд Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газраас зарласан УДШ/20240203009 дугаартай “Даатгалын үйлчилгээ” төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг баримт бичгийн тендер хүлээн авах эцсийн хугацаа болон тендер нээх хугацааг өөрчлөн үргэлжлүүлж байгааг үүгээр мэдэгдэж байна.

ДАРГА



С.ЗАЯАДЭЛГЭР

151702000914